



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/76.

Улаанбаатар хот

Г "Биеийн тамир, спортыг айл өрх иргэн бүрт"
сэдэвт арга хэмжээ, семинар зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилт Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн "Биеийн тамир, спортыг айл өрх иргэн бүрт" сэдэвт арга хэмжээ, семинар зөвлөгөөнийг 2014 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Нийслэлийн 2014 оны шилдэг тэргүүний Биеийн тамир, спортын байгууллагуудыг шалгаруулан шагнасугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах 6.650.000 /зургаан сая зургаан зуун тавин мянган/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үндсэн төсвийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

